



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/240

Улаанбаатар хот

Г Дээд боловсролын чанарын
үнэлгээ хийх тухай Г

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, “Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2.1.3 дахь зорилт, “Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030”-ний 5.1, 5.3 дахь зорилт, Засгийн газрын 2021 оны “Боловсролын зээлийн сангийн талаар авах арга хэмжээний тухай” 264 дүгээр тогтоолын 5 дахь заалт, 2023 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн А/200 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн дүгнэлт, 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн “Хөтөлбөр, арга хэмжээний 2023 оны төсвийн хуваарилалт батлах, эрх шилжүүлэх тухай” А/07 дугаар тушаалын 3.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дээд боловсролын гүйцэтгэлийн үзүүлэлтэд суурилан эрэмбэ, чансаа тогтоох ажлын хүрээнд дээд боловсролын сургалтын байгууллагын шалгуур үзүүлэлтийг нэгдүгээр, сургалтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг хоёрдугаар, тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд их дээд сургуулийн үзүүлж буй үр нөлөөг тодорхойлох шалгуур үзүүлэлтийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тушаалын хавсралтаар баталсан үзүүлэлтийн хүрээнд дээд боловсролын сургалтын байгууллагын эрэмбэ тогтоох, сургалтын хөтөлбөрийн чанарын үнэлгээ хийх ажлыг олон улсын болон дотоодын чанарын үнэлгээний мэргэжлийн байгууллагатай хамтран 2023 оны 08 дугаар сарын 20-ны дотор багтаан зохион байгуулахыг Боловсролын үнэлгээний төв /Л.Ганбат/-д даалгасугай.

3. Дээд боловсролын эрэмбэ тогтоох үйл ажиллагаанд шаардагдах 150 /нэг зуун тавин/ сая төгрөгийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөний 3.6-д заасан зардлаас санхүүжүүлэхийг Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэнд зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Н.Нарангэрэл/-д даалгасугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

14231 0960